

**МОНГОЛ ХЭЛНЭЭС ЧЕХ ХЭЛЭНД, ЧЕХ ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛЭНД
ОРЧУУЛАГДСАН БҮТЭЭЛҮҮД**

Д.Энхжаргал
/МУИС/

Resume: In this research paper we have discussed the most famous translated works from Mongolian into Czech, from Czech into Mongolian and given the research-based information. Translated works from Mongolian into Czech and from Czech into Mongolian were found in the libraries, namely: The National Library of Mongolia, Ulaanbaatar Public Library of Natsagdorj.D, The Library of National University of Mongolia, Municipal Library of Prague. The overview of the translated and published works was done. The paper has two parts: Translated works from Mongolian into Czech and Translated works from Czech into Mongolian.

Түлхүүр үг: Павел Поуха, Монголын нууц товчоо, Б. Ринчен, Бэр цэцэг

БНМАУ, Бүгд Найрамдах Чехословак хоёр улс дипломат харилцаа тогтоогоод 65 жилийг үджээ. Энэ хугацаанд хоёр орны харилцаа нийгмийн бүхий л хүрээнд тодорхой хэмжээгээр өргөжиж ирэв. Эл өгүүлэлд монгол хэлнээс чех хэлнээ, чех хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан зохиол бүтээлийг тодруулах судалгаа хийж, түүнийхээ үр дүнг танилцуулж байна.

Уг судалгааны ач холбогдол нь утга зохиол судлаачид, Чехийн монгол судлаач, Монголын чех судлаачдад судалгаанд тулгуурласан үнэн зөв мэдээлэл өгөхөд оршино.

Чехэд хэвлэгдсэн хамгийн анхны томоохон бүтээл “Монголын хувьсгалын түүх”¹ хэмээх Х.Чойбалсангийн зохиол байсан бөгөөд монголч эрдэмтэн Павел Поуха орчуулж, 1954 онд Чехийн улс төрийн зохиолын хэвлэх үйлдвэрт хэвлэгдэж байжээ. Энэ нь тухайн үеийн хоёр орны нийгмийн байгуулал, соц системийн орнуудын төрийн бодлоготой холбоотой байжээ. Харин Монголд хэвлэгдсэн анхны чех зохиол бол зууны манлай эрдэмтэн Б.Ринченгийн орчуулсан “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” юм.

1. Монгол хэлнээс чех хэлэнд орчуулагдсан бүтээлүүд

1.1. Монголын нууц товчоо

Монголын ард түмний соёлын үнэт өв болсон Монголын Нууц товчоо 1955 онд чехийн монголч эрдэмтэн Павел Поухагийн орчуулгаар хэвлэгдсэн нь монголын ард түмнийг чехийн ард түмэнтэй түүх соёлоороо дамжуулан танилцах боломжийг

¹ Čojbalsan, Chorlógijn (1954) Dějiny mongolské revoluce, překlad Pavla Pouchy, Praha, Státní nakladatelství politické literatury

олгожээ. Монголын нууц товчооны уг орчуулга монгол хэлнээс чех хэлэнд орчуулсан анхны уран зохиолын ном, түүх, соёлын том бүтээл байлаа. Эрдэмтэн Павел Поуха Монголын нууц товчоог “*өнгөрсөн үеийн амьд бүтээл*” гэж нэрлээд түүнийг дэлхийн соёлын маргашгүй үнэт, ховор дурсгалын нэг яах аргагүй мөн хэмээн тодорхойлжээ. Павел Поуха “Монголын нууц товчоо”-г нарийвчлан судалж 1957 онд “*Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дүр*” нэг сэдэвт зохиолоо туурвижээ. Монголын нууц товчоо² 2011 онд мөн Прага хотноо чех хэлээр хэвлэгдсэн байна.

Монголын нууц товчооны чех орчуулгыг судлаачид “...Монголын нууц товчоог чех, мажар, польш хэлээр, түүнийг судлагч монголч эрдэмтэд орчуулсан тул эрдэм шинжилгээний ихээхэн үнэ, цэнтэй бүтээлүүд болжээ. Тэдгээр эрдэмтний хийсэн зүүлт, тайлбарт МНТ-ны судлалд чухал холбогдол бүхий үнэтэй санаа олон бий³ хэмээн үнэлсэн байдаг. Д.Энхжаргал (2013) “Монголын нууц товчооны чех орчуулгын тухайд⁴” өгүүлэлд уг орчуулгын талаар хийсэн судалгааны үр дүнг танилцуулжээ.

1.2. Б. Ринченгийн зохиолууд

1.2.1. Яруу найраг

20-р зууны манлай эрдэмтэн Б.Ринчен Чехийн ард түмнийг монголын уран зохиолтой, монголын ард түмнийг чехийн уран зохиолтой танилцахад чухал үүрэг гүйцэтгэжээ. Их эрдэмтний “Нөхөддөө мэнд хүргэе” (1956), “Тыны сүмд” (1956), “Бэр цэцэг” (1955), “Шидэт толь” зэрэг нь чехийн ард түмэнд зориулан бичсэн яруу найргууд юм. “Нөхөддөө мэнд хүргэе”, “Тыны сүмд”, “Бэр цэцэг” зэрэг нь чехийн орчуулагч Иозеф Петеркагийн орчуулгаар „*Čaj ve stepi*“ буюу “Талын цай” номонд 1979 онд Прага хотод чех хэлээр гарчээ. Эдгээрээс жишээ татвал:

“Нөхөддөө мэнд хүргэе” (Pozdrav přátelům, 1956)

Багш Хусын түмэн балчир сурагч наснаасаа

Бахданхан дурладаг би чинь, үс буурал болсон хойно,

Ах дүү сайхан улс, сэтгэлд минь дотно нутагт чинь

Айлчланхан ирж, баясанхан гийчилж явахдаа

Сайн санаат ард түмнийхээ яруу найрагч би чинь

Садан нөхөд та бүхнээ түмнийхээ мэнд хүргэж ирлээ...

Národě mistra Jana, od školních let

Na tebe myslím, tebou se pyšním, mám rád tvůj svět,

Starí jsem dospěl, a teď, když mi zešedly vlasy

Stal jsem se hostem tvé podivné blízké vlasti.

Přátelské srdce má můj lid, jsem jeho básník, a rád

Přináším ti pozdrav ze země stepí a stád...

“Тыны сүмд” (V Týnském chrámu, 1956)

Маш өндөр, хуучин хотын цамхаг дээрээс

Манант намрын тэр өдөр, хөх униар буданд

² Tajná kronika Mongolů, překlad Pavla Pouchy, 2011, Praha

³ Цэрэнпил Д. Сэржав Б. (1991) Монголын нууц товчооны номзүй, судлалын тойм, УБ

⁴ Энхжаргал Д. (2013) Монголын нууц товчооны чех орчуулгын тухайд, Орчуулгазүй, №1, 186-194

Өлмий дор минь харагдах хотыг хялайн үзвээс
Өндөр цамхгийн орой, эртний богд Витийн сүмийн
Ганжир загалмай нь, хөхрөгч мананг нэвтрэн
Гал шар улаан навчит цэцэрлэг, түмэн байшингийн
Харлан хүрэнгэсэн дээврийг гүүрийн доогуур
Хар гурвалжин могой мэт шургагч Влтавыг
Үүлэн цаанаас нарны гэрэл нэвтрэн гийж билээ...

*Z ochotu Staroměstské radnice modravou mhou,
která v říjnovém šeru na střechách leží,
shlížel jsem na město pod sebou“
kříž starobilého víta, špiše věží
vrstvami mlhy se vzpínaly,
paprsky slunce jim letěly vstříč,
na pestré listí sadů, na temné střechy padaly,
na lesklou vltavu, vpletenou do mostů a do ulic...*

“Бэр цэцэг” найраглал (Густа Фучиковад зориулав.)

Уудам сайхан манай нутгийн
Уул талаар өнгийн цэцэг олон
Онц л түүний дундаас бэр цэцэг
Олны сэтгэлд хайртай сайхан...

*Naše země je plná hor a stepí,
Hory a stepi plné květů,
A z těch všech květů je nám nejmilejší
Nevěstin kvítek: strážka.*

1.2.2. Роман

1.2.2.1. “Заан залуудай” роман

1957 онд Б.Ринченгийн „Заан залуудай” романыг Чехийн нэрт монголч эрдэмтэн Павел Поуха чех хэлээр орчуулж, Чехословакийн шинжлэх ухааны академийн хэвлэлийн газар хэвлэн гаргасан байна. Заан залуудайг “Nejlepší z mužů Džang-Džalúdaj” буюу “Эрийн сайн Заан Залуудай” хэмээх нэрээр гаргасан нь зохиолын утга санааг чехийн ард түмэнд илүү ойлгомжтой болгоход тус дөхөм болжээ.

1.2.2.2. “Үүрийн туяа” роман

1958 онд Б.Ринченгийн “Үүрийн туяа” романыг Павел Поуха “Slunce vychází”⁵ буюу “Нар мандаж байна” нэрээр монгол хэлнээс чех хэл рүү орчуулж, Чөлөөт үг-Мелантрих хэвлэлийн газар хэвлүүлэн гаргасан байна.

1.3. Монголын бусад зохиолчдын бүтээл

1.3.1. Ч. Лодойдамбын бүтээл

1976 онд Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романыг “Прозрачный Тамир” буюу уг зохиолын орос орчуулгаас чех хэлэнд орчуулагч Анна Новакова дам орчуулан „Průzračný Tamir”⁶ нэрээр Свобода⁶ хэвлэлийн газарт хэвлэн гаргасан

⁵ Bjambyn Rinčen (1958) Slunce vychází, překlad Pavla Pouchy, Svobodné slovo Melantrich, Praha

⁶ Lodojdamba Č. (1976) Průzračný Tamir, Svoboda, překlad Anny Novákové, 1976

байна. Энэхүү орчуулга 1980 онд мөн хоёр дахь удаагаа Ардын хэвлэлийн газар⁷-т хэвлэгдсэн байна.

1.3.2. Д. Цэвэгмидийн бүтээл

1974 оны Д.Цэвэгмидийн “Зохиолууд” номны монгол эх нь “Ryzák Vítr” нэрээр Иржи Шимагийн орчуулгаар 1986 онд Прагийн Албатрос хэвлэлийн газарт хэвлэгдсэн байна. Уг номд Хүйсийн говь, Хоньчин Найдан, Ардын зоригт баатар, Салхин зээрд, Хун шувуу бодон гахай хоёр, Хойлогийн дуу, Ёлын үүр, Хос тогоруу, Өглөөтэй золгосон нь, Хайр, Сартай шөнө, Соёлын зул бадраасан нь⁸ зэрэг бүтээлүүд нь оржээ.

1.3.3. Яруу найрагчдын бүтээл

1979 онд Čaj ve stepi буюу “Талын цай” (Монголын орчин цагийн 10 яруу найрагч)⁹ хэмээх бүтээлийг Иржи Шима болон бусад орчуулагчид хамтран орчуулж гаргасан. Эл номонд Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ч.Лхамсүрэн, Ч.Чимид, Б.Явуухулан, М.Цэдэндорж, Д.Пүрэвдорж, М.Ширчинсүрэн, Ш.Дулмаа, С.Дашдооров нарын 62 яруу найргийн бүтээл оржээ.¹⁰

Эдгээр яруу найргийг эхтэй нь тулган уншиж, орчуулга эх хоёрыг зөв дүйцүүлэх ажилд багагүй саад гарч байсныг өгүүлэх юун. Зохиолын нэр зөрүүтэй орчуулагдсан тул нэлээд олон бүтээл унших шаардлага гарсан. 62 яруу найргийн бүтээлийн тавь орчмыг орчуулга, монгол эхтэй нь тулган олж чадсан бол, зарим нь олдсонгүй.

“Талын цай” номд орсон монголын яруу найрагчдын бүтээл

№	Зохиогч	Зохиолын нэр монголоор	Зохиолын нэр чехээр	Орчуулсан
1	Бямбын Ринчен	Нөхөддөө мэнд хүргэе	Pozdrav přátelům	Иозеф Петерка
		Тыны сүмд	V Týnském chrámu	
		Бэр цэцэг	Stračka velkokvěta	
2	Цэндийн Дамдинсүрэн	Гэсэрийн баатрын магтаал	Chvalozpěv na hrdiny	Иржи Жаачек
		Анчны дуу	Píseň lovce	
		Хайрын захидал	Milostný dopis	
		Найрын дуу	Hodovní píseň	
		Наалинхай хоёр нүд чинь	Tvoje oči plné něhy	
Бүүвэйн дуу	Ukolébavka			
3	Чойжилжавын Лхамсүрэн	Шөнийн Улаанбаатар	Ulábátar v noci	Иозеф Петерка
		Дөрвөн мөрт	Čtyřveši	
		Эдгээр шүлгүүдийн монгол эхийг олж чадаагүй тул монгол нэрийг оноож бичсэнгүй.	Skály v rodném kraji	
			Vítání hostí	
		Fotografie		
		Holčička maluje moře		

⁷ Lodojdamba Č. (1980) Průzračný Tamir, Lidové nakladatelství, překlad Anny Novákové, 2. vyd.

⁸ Цэвэгмид Д. (1974) Зохиолууд, УБ, УХГ

⁹ Čaj ve stepi, Praha, československý spisovatel, 1979

¹⁰ Энхжаргал Д. (2010) Монголын уран зохиол Чехэд, Гадаад хэл соёл судлал, №333(14), 65-74

4	Чойжилын Чимид	Лимбэчин	Flétnista	Иржи Шима
		Эх орон өлгий минь	Vlast, má kolébka	
		Намар цаг	Podzim	
		Хоёр гургалдай	Dva slavíci	
		Говийн дуу	Gobijská píseň	
		Санасан бодсоноо хэлэхэд	Tobě	
5	Бэгзийн Явуухулан	Гэр	Jurta	Иржи Жаачек
		Сайхан чамдаа	Tobě má láska	
		Ай даа дуул алтан гургалдай минь	Zpívej zpívej slavíčku	
		Эх орны тухай дуу	Píseň o vlasti	
		Чи минь наддаа ирнэ.	Přijdeš ke mne	
		Алтайн оргил	Vrchol Altaje	
		Гэнэн насны дурлалын хойноос дуулсан дуу	Píseň o lásce z mladí	
		Цаг ирлээ ч гэсэн би үхэхгүй	Až se dovrší můj čas	
6	Мишигийн Цэдэндорж	Хүн хүндээн	Člověk člověku	Владимир Яновиц
		Уурга барьж өссөн би	Vyrůstal jsem s úrgou v ruce	
		Хасаг өвгөнд бичсэн захидал	Dopis starému Kazachovi	
		Эдгээр шүлгүүдийн монгол эхийг олж чадаагүй	Čtvero štěstí světa	
		тул монгол нэрийг оноож бичсэнгүй.	Pouto lásky Surgál neboli naučení mladšímu bratrovi	
7	Дэндэвийн Пүрэвдорж	Чи минь битгий мартаарай	Nezapomeň na mě	Владимир Яновиц
		Хээрийн цай	Čaj uprostřed stepi	
		Эдгээр шүлгүүдийн монгол эхийг олж чадаагүй	Jestli mě nemiluješ	
		тул монгол нэрийг оноож бичсэнгүй	Já nechci do ráje	
8	Мишигийн Ширчинсүрэн	Ай намар цаг, намар цаг	Sladký podzim	Карел Сийс
		Хайр	Láska	
		Хүүгээ санаж явна	Myšlenka na syna	
		Дөрвөн мөрт	Čtyřverší	
		Өгүүлэл	Vyznání	
		монгол эхийг олж чадаагүй тул монгол нэрийг оноож бичсэнгүй.	Maminčin čaj	

9	Шагдарын Дулмаа	Бүсгүй	Divčí úsměv	Яна Моравцова
		Газар шороондоо би хайргай	Mám ráda svůj rodný kraj	
		Эцгийн голомт	Otcovský krb	
		Эдгээр шүлгүүдийн монгол эхийг олж чадаагүй тул монгол нэрийг оноож бичсэнгүй	Vzpomínky na venkov Vlny modravého jezera Můj kůň	
10	Сормууниршийн Дашдооров	Би хоньчин явлаа	Když jsem byl ovčákem	Карел Сийс
		Ширүүн борооны өмнөхөн	Před líkákem	
		Чиний гоо сайхан	Tvoje krása	
		Цонхны цаана хүүхнүүд инээлдэнэ.	Divky za oknem	
		Амьдын жаргал	Štěstí života	
		Мөнх нэгэн цэцэг	Květina věčně zelená	
		Нүүдлийн шувууд	Stěhovací ptáci	
Монгол зан	Mongolská povaha			

Б. Явуухулангийн яруу найргийн түүвэр Ирши Шима, Вацлав Данийк нарын орчуулгаар “Hvězdy v rouští” (Говийн одод) нэрээр 1974 онд Чехэд хэвлэгджээ. Мөн түүнчлэн Pod azurovým nebem¹¹ (Номин хөх төнгөрийн дор) нэрээр Явуухулангийн түүвэр зохиол Иржи Шима, И.Хорженовский нарын орчуулгаар 1977 онд Прага хотноо гарчээ. Эдгээр номын чех орчуулгыг олж танилцаж чадаагүй тул Б.Явуухулангийн ямар бүтээлүүд орчуулагдсаныг мэдэх боломжгүй байлаа.

2. Чех хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан бүтээлүүд

2.1. Б. Ринченгийн орчуулсан бүтээл

2.1.1. “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” (Reportáž psaná na oprátce)

Нацист германы эсрэг тэмцэлд оролцсоныхоо төлөө 1943 оны 9-р сарын 8-нд Берлинд цаазлуулсан Чехийн сэтгүүлч, утга зохиол шүүмжлэгч Юлиус Фучик (1903-1943)-ийн Панкрац дахь гестапын гянданд 1943 оны хавар бичсэн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” (Reportáž psaná na oprátce) зохиолыг нэрт эрдэмтэн Б. Ринчен 1951 онд чех хэлнээс монгол хэлнээ орчуулан Улаанбаатар хотноо хэвлүүлжээ. Уг зохиолыг Юлиус Фучикийн эхнэр Густа Фучикова 1945 онд Прага хотноо нөхрийнхөө дурсгалд зориулан хэвлүүлсэн аж. Хожим нэрт эрдэмтэн Б.Ринчен “Бэр цэцэг” (редактор Д.Тарва, УХГ, 1958) яруу найргийн түүвэр хэвлүүлэхдээ Юлиус Фучикийн гэргий Густа Фучиковад зориулан “Бэр цэцэг” найраглалын эхэнд “Густа Фучиковад зориулав” гэж бичсэн байдаг нь дэлхийн түүхэнд эртнээс өнөөг хүртэлх хугацаанд болсон дайн самуун, дэлхийн хоёрдугаар дайнд эрэлхэг нөхрөө дайнд алдсан гэргий нарт зориулсан хэрэг байжээ.

2.1.2. Эртний чех домог тууж (Staré pověsti české)

Чехийн зохиолч Алоис Йираасек (1851-1930)-ийн бичсэн “Эртний чех домог тууж” (Staré pověsti české) номыг Б.Ринчен 1965 онд орчуулан Улаанбаатар хотноо

¹¹ <http://www.mlp.cz/en/>

хэвлүүлжээ. Уг номонд: Чех жанжны домог, Крок охид сэлтийн домог, Бивойн домог, Либүшийн домог, Пшемыслийн домог, Либүшийн Бошог домог, Охидын дайн, Кшесомысл Хоримийр хоёрын домог, Лүкүүдийн дайн, Дүринк Неклай хоёрын домог, Сватоплук вангийн домог, Арвайхүү ноён, Богд Вацлавын Хийр, Брунцвигийн домог, Опатовицын Эрдэнэсийн сан, Хуучин Прагийн домог гэсэн домгууд багтсан аж. Орчуулагч хоёр дахь ботийг Чехийн эртний домог II нэрээр 1968 онд хэвлүүлсэн аж. Уг бүтээл Чехийн ард түмний түүх соёлтой Монголын ард түмнийг танилцуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

2.2. Д. Алтангэрэлийн орчуулсан бүтээлүүд

2.2.1. “Тэнгэрийн элч” өгүүллэгийн түүвэр

Нэрт орчуулагч Д. Алтангэрэл чех, словак хэлнээс Юлиус Фучикийн “Коммунизмын тугийн дор”, Марие Пуймановагийн “Амьдрал”, Иржи Марекийн “Уулзахын ерөөл”, Вацлав Ржезачийн “Долоон танк”, Ян Дрдагийн “Байлдагч Станда”, Марие Маеровагийн “Хотын захын хориглолт”, Людвик Ашкеназийн “Сонгино”, Франтишек Куфкагийн Цэцгийн багц”, Петр Йилемницкийн “Тэнгэрийн элч”, Рудольф Калчикийн “Ганцаардал”, Владимир Миначийн “Шийдэхийн өмнөхөн” зэрэг өгүүллэгүүдийг Д.Бадарчийн хамт орчуулан “Тэнгэрийн элч” (УБ, 1970) гэсэн нэрээр хэвлүүлсэн.

2.2.2. “Ромео, Жульетта хоёр харанхуйд”

Чехийн зохиолч Ян Отченашекийн “Ромео, Жульетта хоёр харанхуйд” буюу “Romeo, Julie a tma” (1958) бүтээлийг Д.Алтангэрэл орчуулан 1975 онд хэвлүүлжээ.

2.2.3. Хөгжөөнт үлгэрийн ном: үлгэрийн цоморлиг

Маерова Мариегийн “Хөгжөөнт үлгэрийн ном: үлгэрийн цоморлиг” хэмээх номыг мөн орчуулж, 1979 онд Ардын Боловсролын яамны зөвшөөрлөөр хэвлэн гаргасан байна.

2.2.4. “Михал дарга”

Чехийн зохиолч Ян Козакийн “Михал дарга” буюу “Svatý Michal” (1971) зохиолыг чех хэлнээс монгол хэлнээ Д.Алтангэрэл мөн орчуулж, 1981 онд хэвлүүлсэн ба Г. Амар редакторласан ажээ.

2.2.5. “Тожмой луутай тулалдсан нь”

Карел Чапекийн “Válka s mlouky” зохиол Д.Алтангэрэлийн орчуулгаар 1988 онд “Тожмой луутай тулалдсан нь” нэрээр Улаанбаатар хотноо гарчээ.

2.3. Бусад орчуулагчдын орчуулсан бүтээл

Витезслав Незвалын “Zpřev míru” (1950) буюу “Энх тайвны дуу” яруу найргийн түүвэр (орч. Х.Пэрлээ, УБ, 1954), Дрда Яны “Өгүүллэгүүд” (УБ, 1952), Марек Иржигийн “Nad námi svítá” буюу “Манайд үүр гийлээ” (орч. Ц.Дүгэрсүрэн УБ, 1955), “Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд, (орч. У.Лийгаа, УБ, 1956), Ян Амос Коменский (УБ, 1958), Ярослав Хашекийн “Osudy dobrého vojáka Švejka” (1921-1923) буюу “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” (орос хэлнээс орч. Ш. Очирбат, УБ, 1965, 2009), Юлиус Фучикийн “O třech písmenkách” буюу “Холбоочны гурван үсэг” (орчуулагч Д.Хишигжаргал, УБ, 1966), Пуйманова Мариегийн “Hra s ohněm” буюу “Галаар наадвал” роман (Г. Дашдаваа, УБ, 1974),

Божена Немцовагийн “Babička” буюу “Эмээ” (орч. Г. Дашдаваа, УБ, 1987), Ян Ленчогийн “Дурсамж” (орч. П.Нямаа, УБ, 1989), Карла (орч. Л.Тойв, УБ, 1956) Карел Чапекийн “Илд бамбай” (Kraakatit, 1993), Франц Кафкагийн “Proces” буюу “Шүүх ажиллагаа” (орос хэлнээс орч. Ц.Сүхбаатар, УБ, 2009), Чехийн шилдэг үлгэрүүд (орч. Д.Энхжаргал болон бусад, УБ, 2010) зэрэг бүтээлүүдийг монгол хэлнээ хөрвүүлжээ. Ю.Фучикийн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” дэлхийн 80 хэлэнд¹², Я.Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” 58¹³ гадаад хэл дээр, Божена Немцовагийн “Эмээ” роман 21 гадаад хэлээр орчуулагдсан¹⁴ алдартай бүтээлүүд билээ.

ДҮГНЭЛТ

- Монгол Улсын Төв номын сан, Д.Нацагдоржийн нэрэмжит номын сан, Монгол Улсын Их сургуулийн номын сан зэрэгт буй чех хэлнээс монгол хэлэнд орчуулж, нийтийн хүртээл болсон зохиолуудын тоймыг гаргалаа. Мөн түүнчлэн монгол хэлнээс чех хэлэнд хөрвүүлсэн монгол зохиолчдын бүтээлийг БНЧУ-ын номын сангууд болон цахим хуудсанд байршсан мэдээлэл, МУИС-ийн номын санд буй эх сурвалжийг ашиглан тогтоосон болно.
- Монголч эрдэмтэн Павел Поухагийн орчуулсан “Монголын нууц товчоо”-ны чех орчуулга, Б.Ринченгийн “Үүрийн туяа”, “Заан залуудай” романууд зэрэг нь үнэ цэнтэй судалгааны эх сурвалж болно.
- Монголын алдартай бүтээлүүдээс Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романыг зөвхөн дам орчуулсан бол бусад зохиолуудыг шууд эх хэлнээс орчуулжээ.
- Чех хэлнээс монгол хэлнээ эрдэмтэн Б.Ринчен “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” (Reportáž psaná na oprátce) Эртний чех домог тууж I, II (Staré pověsti české) зэрэг нэртэй бүтээлүүдийг буулгажээ.
- Б.Ринчен Чехийн ард түмэнд зориулан яруу найраг бичиж, чех зохиолчдын бүтээлээс орчуулж, олон арван судалгааны өгүүлэл бичсэн, түүний бүтээлүүд чех хэлнээ орчуулагдсан зэргийг эл эрдэмтний Чехийн монгол судлал, Монголын Чех судлалд оруулсан томоохон хувь нэмэр гэж үзнэ.
- Чех хэлнээс монгол хэлнээ олон зохиол бүтээл орчуулсан хүн бол яах аргагүй нэрт орчуулагч Д.Алтангэрэл бөгөөд тэрээр “Тэнгэрийн элч” өгүүллэгийн түүвэр, “Ромео, Жульетта хоёр харанхуйд”, Хөгжөөнт үлгэрийн ном: үлгэрийн цоморлиг, “Михал дарга”, “Тожмой луутай тулалдсан нь” зэрэг бүтээлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд, орчуулагчийн ур чадварыг харуулан орчуулжээ.
- Чех хэлнээс орос хэлээр дамжин монгол хэлэнд дам орчуулагдсан бүтээлүүд нь Я.Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал”, Ф.Кафкагийн “Шүүх ажиллагаа” зэрэг байна.
- Зууны манлай эрдэмтэн Б.Ринчен, орчуулагч Д.Алтангэрэл, Чехийн монголч эрдэмтэн Павел Поуха, Иржи Шима нарын орчуулах эрдэм, ур чадвараас залуу судлаач бид суралцах нь зүйтэй.
- Монголд орчуулан хэвлэсэн чехийн уран зохиол, Чехэд хэвлэгдсэн

¹² <http://antiskola.eu/cz/referaty/9503-julius-fucik-reportaz-psana-na-opratce>

¹³ cs.wikipedia.org/wiki/Osudy_dobrého_vojáka_Švejka_za_světové_války

¹⁴ <http://www.muzeumbn.cz/babicka-150/>

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН БҮТЭЭЛҮҮДИЙГ СУДЛААЧИД ХАРИЛЦАН СОЛИЛЦОЖ, ХОЁР УЛСЫН ТОМООХОН НОМЫН САНГУУДАД БАЙРШУУЛАХ, УНШИГЧДАД ХҮРГЭХ, СУДАЛГААНЫ ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд, орч. У.Лийгаа, УБ, 1956
2. Божена Немцова (1987) Эмээ, чех хэлнээс орч. Г.Дашдаваа, УБ, УХГ
3. Витезслав Незвал (1954) Энх тайвны дуу, яруу найргийн түүвэр, орч. Х.Пэрлээ, УБ
4. Дамдинсүрэн Ц. (2003) Монголын нууц товчоо, Мөнхийн үсэг, УБ
5. Дашдооров С. (1978) Тал бид хоёр, шилмэл шүлгийн түүвэр, УБ, УХГ
6. Дулмаа Ш. (1989) Талын энгэр, УБ, УХГ
7. Карел Чапек (1988) Тожмой луутай тулалдсан нь, чех хэлнээ орч. Д.Алтангэрэл, УБ, УХГ
8. Лхамсүрэн Ч.(1978) Манай үеийн баатар, УБ, УХГ
9. Марек Иржи (1955) Манайд үүр гийлээ, орч. Ц.Дүгэрсүрэн УБ
10. Монголын уран зохиолын дээжис, 7-р боть, Нууц янаг, УБ, МУЗ х.г. 1994
11. Монголын уран зохиолын дээжис, 27-р боть, Цогт тайж, МУЗ х.г, УБ, 1997
12. Монголын уран зохиолын дээжис, 26-р боть, УБ, МУЗ х.г.1997
13. Монголын уран зохиолын дээжис, 34-р боть, УБ, МУЗ х.г 1998
14. Монголын уран зохиолын дээжис, 35-р боть, Эрээн уул, УБ, МУЗ х.г 1998
15. Монголын уран зохиолын дээжис, 36-р боть, УБ, Ботьбилэг х.г., 2006
16. Монголын уран зохиолын дээжис, 44-р боть, Магеллан хаагуур явсан бэ?, УБ, МУЗ х.г. 1998
17. Монголын уран зохиолын дээжис, 51-р боть, Бурханбуудайн хөх салхи, 51-р боть, УБ, МУЗ х.г 1998
18. Монголын уран зохиолын дээжис, 54-р боть, Шувуутай мод, УБ, МУЗ х.г 1998
19. Монголын уран зохиолын дээжис, 79-р боть, Би ертөнцийн хүүхнүүдийн нэг, УБ, МУЗ х.г 2000
20. Монголын шилдэг яруу найраг, УБ, УХГ, 1981
21. Пуйманова Марие (1974) Галаар наадвал, роман, орч.Г.Дашдаваа, УБ
22. Ринчен Б. (1959) Бэр цэцэг, Яруу найргийн түүвэр, редактор Д.Гарва, УХГ
23. Тэнгэрийн элч, чех, словак хэлнээс орч. Д.Алтангэрэл, УБ, 1970
24. Франц Кафка (2009) Шүүх ажиллагаа, Дэлхийн сонгодог зохиол, 19-р боть, Монсудар, орос хэлнээс орч. Ц.Сүхбаатар
25. Цэвэгмид Д. (1974) Зохиолууд, УБ, УХГ.
26. Цэрэнпил Д. Сэржав Б. (1991) Монголын нууц товчооны номзүй, судлалын тойм, УБ
27. Чехийн шилдэг үлгэрүүд, орч.Д.Энхжаргал болон бусад, УБ, 2010
28. Чимид Ч (1984) Түүвэр зохиол, 1-р боть, Яруу найраг, УБ, УХГ.
29. Ширчинсүрэн М. (1987) Хүслийн хүлэг, УБ, УХГ.
30. Ширчинсүрэн М. (1991) Өгсүүр зам, УБ, МУЗ Х.Г.

31. Энхжаргал Д. (2010) Монголын уран зохиол Чехэд, Гадаад хэл соёл судлал, №333(14), 65-74
32. Энхжаргал Д. Монголын нууц товчооны чех орчуулгын тухайд, Орчуулгазүй, №1, 2013, 186-194
33. Юлиус Фучик (1951) Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл, орч. Б. Ринчен, УБ,
34. Юлиус Фучик (1966) Холбоочны гурван үсэг, орч. Д. Хишигжаргал, УБ
35. Явуухулан Б. (1985) Түүвэр зохиол, УБ, УХГ
36. Ян Амос Коменский УБ, 1958
37. Ян Козак (1981) Михал дарга, чех хэлнээс орч. Д. Алтангэрэл, УБ, УХГ
38. Ян Ленчо (1989) Дурсамж, орч. П. Нямаа, УБ
39. Ян Отченашек (1975) Ромео Жульетта хоёр харанхуйд, чех хэлнээс орч. Д. Алтангэрэл, УБ, УХГ
40. Ярослав Хашек (1965) Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал, орос хэлнээс орч. Ш. Очирбат, УБ, УХГ
41. Ярослав Хашек (2009) Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал, орос хэлнээс орч. Ш. Очирбат,
42. Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган, 36-р боть, УБ, Монсудар

Чех хэлээр

43. Cevegmid D (1986) Ryzák Vítr, Praha, Albatros
44. „Čaj ve stepi“, československý spisovatel, Praha, 1979
45. Julius Fučík (1943) Reportáž, psaná na oprátce
46. Lodojdamba Č. (1976) Průzračný Tamir, Svoboda, překlad Anny Novákové, 1976
47. Lodojdamba Č. (1980) Průzračný Tamir, Lidové nakladatelství, překlad Anny Novákové, 2.vyd.
48. Rinčen B. (1957) Nejlepší z mužů Dzáng-Dzalúdaj, Nakladatelství Československé akademie věd: Praha
49. Rinčen B. (1958) Slunce vychází, překlad Pavla Pouchy, Svobodné slovo Melantrich, Praha
50. Tajná kronika Mongolů, Praha, překlad Pavla Pouchy, Praha, státní nakladatelství, krásné literatury, hudby a umění, 1955
51. Tajná kronika Mongolů, Praha, překlad Pavla Pouchy, Praha, Lidové noviny, 2011
52. <http://www.obecprekladu.cz>
53. <http://antiskola.eu/cz/referaty/9503-julius-fucik-reportaz-psana-na-opratce>
54. cs.wikipedia.org/wiki/Osudy_dobrého_vojáka_Švejka_za_světové_války
55. <http://www.muzeumbn.cz/babicka-150/>
56. <http://www.mlp.cz/en/>